# МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2023.12.17 Мандалговь хот

| Бүлэг | Хуулийн заалт | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|
| 1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгууллалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 8.2 | 1.1 | Үйл ажиллагааны стратегийн зорилго ажиллагааны стратегийн зорилт үйл тэргүүлэх чиглэл тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн | Хүнс хөдөө аж ахуйн эрхэм зорилго: Уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуй, орон нутгийн онцлогт тохирсон дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэн аймгийнхаа эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох энэхүү эрхэм зорилгыг мэдээллийн ил тод сайтад байршуулан ажиллаж байна. | 100 |
| | | | 2020 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээний 37.84 хувийг орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангаж байсныг 2024 онд 56-аас доошгүй хувьд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2020 оноос ахиулан 2024 онд 294,221.45 сая.төгрөгт хүргэх. | |
| | | | Мал аж ахуй газар тариалан хүнсний болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ , хоршоо, дотоод худалдааны салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, урт богино дунд хугацааны бодлогын баримт бичиг, хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд саналаа хүргэх, орон нутгийн түвшинд төлөвлөх боловсруулах салбарын чиглэлээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, салбарын статистак мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээ мэдээллээр хангах зэрэг Стратегийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд ерөнхий 8 зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Ил тод сайтад байршуулсан. | |
| | | | Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн жижиг дунд үйлдвэр, газар тариалан худалдаа үйлчилгэг зах зээлд өрсөлдөхүйц хөгжлийн шинэ шатанд гаргаж, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуйг хөгжүүлж,, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх | |
| | | | Уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуй, орон нутгийн онцлогт тохирсон дэвшилтэд технологи бүхий үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлж, аймгийнхаа эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох зорилгыг дэвшүүлж аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн стратеги болон хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2021-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөнд нийт 8 чиг үүргийн хүрээнд 10 зорилт 45 арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | 1.2 | Чиг үүрэг Бүтэц, зохион байгуулалт хаяг, байршил харилцах утасны дугаар шуудангийн хаяг олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг | Төрийн захиргааны удирдлагаар хангах, бүтцийн дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, салбарын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, төсөв боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, санхүүгийн байдлыг тайлагнах, Мал аж ахуйн үйлдвэрлэл, малын генетик нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого, хөтөлбөрийн төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, Хүнсний болон хоол үйлдвэрлэлд үнэ цэнийн болон кластерийн сүлжээг хөгжүүлэх, хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, салбарт хоршооны салбарын санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудал | 100 |
| | | | Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Захиргаа аж ахуйн алба, Мал үржлийн алба, Үйлдвэр худалдаа үйлчилгээний алба, Хяналтын алба гэсэн бүтэцтэйгээр нийт 22 албан хаагч салбарын чиглэлээр гарсан төр засгийн бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, дүрэм, журмыг сурталчилан орон нутагт хэрэгжилтийг зохион байгуулан ажилладаг. | |
| | | | Дундговь аймаг, Сайнцагаан сум 7-р баг, ХХААГ-ын гудамж 104 тоот | |
| | | | (976) 7059 2586 | |
| | | | Цахим шуудан: Mofa@dundgovi.gov.mn | |
| | | | https://www.facebook.com/profile.php?id=10076045924978 | |
| | 1.3 | эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт үйл ажиллагааны тайлан мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит санхүүгийн хяналт | 2023 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг жилийн эцсийн байдлаар гарган тайлагнасан. | 100 |
| | | | Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнасан. | |
| | | | Хүнс, хөдөө аж ахуйн газрын ил тодын үйл ажиллагаанд 2023 оны хагас, бүтэн жилээр аймгийн ХШҮ хэлтэсээс хяналт үнэлгээ хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж | | |
| | 1.4 | хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан | Хууль эрх зүйн хэлтсээр газрын даргаас гарсан тушаалыг хагас, бүтэн жилээр хянуулж ажиллаж байна. | 100 |
| | 1.5 | хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр-100, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт-,86,1 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр-97,5, Байгууллагын стратеги төлөвлөгөө- 90,7 , Аймгийн стратеги төлөвлөгөө-80,3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргатай байгуулсан гэрээ-95,3, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө- 99,3, Аймгийн Засаг дарга ХХААГ-ын даргын байгуулсан гэрээ-100 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж хувь 93.6% | 100 |
| | 1.6 | үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт | Хүнс, хөдөө аж ахуйн газрын ЗАААалба, МАА-н алба, ҮХҮАлба, Хяналтын албатуудтай холбоотой нийт 85 гаруй хууль, Засгийн газрын тогтоолуудыг ажил албандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |
| | 1.7 | албан тушаалын тодорхойлолт<br>албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр<br>албаны харилцах утасны дугаар<br>албаны цахим шуудангийн хаяг | Хүнс хөдөө аж ахуйн газрын нийт 19-н албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг ил тод байршуулаад байна.<br>Хүнс, хөдөө аж ахуйн газрын 17-н албан хаагчдын танилцуулга овог нэр, албан тушаалын нэр зэргийг тусгайлан нэг нэгээр танилцуулган дээр оруулан ил тодод байршуулсан.<br>ХХААГ утас: (976) 7059 2586<br>Цахим шуудан: www.dundgovi.gov.mn | 100 |
| | 1.8 | өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ | 2023 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар тайлагнасан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 1.9 | хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл | | |
| | 1.10 | мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр | Хүнс хөдөө аж ахуйн газрын мэдээлэл хариуцагч нь 2 хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд өөрийн байгууллагын ил тодын мэдээг албатуудаас авч нэгтгэн сайтад байршуулах мөн facebook цахим хуудасыг хөтөлж цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг цаг алдалгүй иргэдэд шуурхай хүргэн ажиллаж байна. Мөн тухайн байгууллагад ирсэн өргөдөл гомдлыг цахимд шивэн шийдвэрлэлтийн мэдээг хугацаанд нь мэдээлэн ажиллаж байна. | 100 |
| Дундаж оноо | | | | 93,6 |
| 2. Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 2.1 | ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл | Мал үржлийн албаны сул 2 орон тооны захилгыг төрийн албаны салбар зөвлөлийн аймгийн салбар зөвлөлд газрын даргын 2023 оны 01/34 тоот албан бичгээр хүргэн ажилласан. Байгууллагын цахим сайт болон мэдээллийн самбар, төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд мэдээлсэн. Тусгай шалгалтад 1 албан хаагч тэнцэн ажиллаж байна. | 100 |
| | 2.2 | албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам | Төрийн албан хаагчийнг сонгон шалгаруулах журмыг ил тодод байршуулсан. | 100 |
| | 2.3 | албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм | Хүнс хөдөө аж ахуйн газрын нийт 19-н албан хаагчдын ажилтны ёс зүйн дүрэм мөн ёс зүйн гэрээг ил тод байршуулаад байна. | 100 |
| | 2.4 | хүний нөөцийн стратеги түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам | Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоол, журам, зааварыг үндэслэн Хүнс хөдөө аж ахуйн газрын хөгжлийн стратеги /хэтийн / төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгууллагын даргын 2021 оны А/14 тоот тушаалаар байгуулан, 2021-2024 он хүртэлх Дундговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэ стратеги төлөвлөгөөнд байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, эрхэмлэх зарчим, стратегийн зорилт, хүрэх үр дүн, хамрах хүрээ, байгууллагын бүтэц, хүний нөөц, хяналт шинжилгээ гэх мэт асуудлуудыг тусгасан болно. Дээрх стратеги төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулан, байгууллагын даргын 2018 | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | оны А/18 тоот тушаалаар батлуулж хөтөлбөртэй уялдуулан 2023 оны жилийн төлөвлөгөө гарган, 93 хувьтай хэрэгжүүлэн ажилласан.. Мөн байгууллагынхаа вэб сайт болон мэдээлэлийн самбарт байршуулан иргэд олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.Сумдын хөдөө аж ахуйн тасагт нийт 20-н албан хаагч ажиллаж байна. Дутагдалтай байгаа албан хаагч 25, боловсон хүчний хангалт 44,4 хувьтай байна. ХААИС-ийн Зоо инженер технологийн ангийг төгссөн оюутныг аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”ийн хүрээнд сургалтын төлбөрийн дэмжлэгт хамруулж, суманд ажиллахаар болоод байна. Төрийн албаны шалгалтад тэнцсэн. www.dundgovi.gov.mn Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нэртэй фейсбүүк хуудас, Дундговь аймгийн www.dundgovi.gov.mn сайтын Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаа мэдээлэл оруулах хэсэгт тайлан мэдээллийг оруулсан. | |
| | 2.5 | хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ | Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ шатлалын судалгааг гаргаж, газрын даргын 2023 оны А/01 дугаар тушаалаар баталж, мөрдөн хэрэгжүүлж байна. Төрийн алба хаасны хугацааны нэмэгдлийг төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан албан тушаалын үндсэн цалингаас бодож олгож байна.<br>Аймгийн Засаг даргын 2023 оны 03 сарын 01 өдрийн А/92 дугаар захирамж, ХХААГазрын даргын Б/10 дугаар тушаалаар төрийн захиргааны дэс түмэл 2 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон.Нийт 20 албан хаагч төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд хамрагдаж 2%-23% нэмэгдэл авч байна. www.dundgovi.gov.mn Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нэртэй фейсбүүк хуудас, Дундговь аймгийн www.dundgovi.gov.mn сайтын Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаа мэдээлэл оруулах хэсэгт тайлан мэдээллийг оруулсан. | 100 |
| | 2.6 | албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам | Журмын дагуу хагас бүтэн жилээр албан хаагчдын ажлыг дүгнэж 40 хүртэл хувийн үр дүнгийн урамшууллыг олгож байна. www.dundgovi.gov.mn Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нэртэй фейсбүүк хуудас, Дундговь аймгийн www.dundgovi.gov.mn сайтын Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаа мэдээлэл оруулах хэсэгт тайлан мэдээллийг оруулсан. | 100 |
| Дундаж оноо | | | | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 3.1 | өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл | www.shilendans.gov.mn 100 хувь байршуулсан | |
| | 3.2 | төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан | www.shilendans.gov.mn 100 хувь байршуулсан | |
| | 3.3 | санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт | www.shilendans.gov.mn 100 хувь байршуулсан | |
| | 3.4 | хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ | www.shilendans.gov.mn 100 хувь байршуулсан | |
| | 3.5 | төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | www.shilendans.gov.mn 100 хувь байршуулсан | |
| | 3.6 | таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг | www.shilendans.gov.mn 100 хувь байршуулсан | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 3.7 | цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | www.shilendans.gov.mn 100 хувь байршуулсан | |
| | 3.8 | бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | www.shilendans.gov.mn 100 хувь байршуулсан | |
| | 3.9 | шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл | Төсвийн тухай хуулийн 8.8.1 заасны дагуу төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх гэсэн заалтын дагуу хуулийн хугацаанд нь мэдээг бүрэн мэдээлсэн.<br>Төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнан ажиллаж байна.<br>Шилэн дансны тухай хуулийн зорилтын дагуу улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэн, олон нийтэд ил тодод байршуулах ёстой 175 мэдээллийг хуулийн хугацаанд нь 100 хувь байршуулан ажилласан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдуулан тухайн байгууллагын төсвийн сахилга батыг чанд баримтлан хуулийн дагуу захиран зарцуулан ажилласан. www.shilendans.gov.mn | |
| | 3.10 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан | Хамааралгүй | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 3.11 | худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт | | |
| | 3.12 | Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл | Монгол улсын засгийн газрын 388 тогтоолын 5,4-ыг мөрдөн ажиллаж байна.<br>2023 онд шатах, тослох материал авах БМБ ХХК-тай, бичиг хэрэг аж ахуйн материал Номгон Рашаан ХХК, сэлбэг хэрэгсэл, авто засвар иргэн П.Батбилэг, Урсгал засвар барилгын материал Буянт чандмань ХХК тай тус тус гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж байна. Нийт 12,1 сая төгрөг зарцуулсан. | 100 |
| | 3.13 | Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; хэрэгжилт, явц, үр дүн | Хүнс, хөдөө аж ахуйн газраас “Газар тариалангийн техник хэрэгслийг сайжруулах” чиглэгдсэн төсөл боловсруулан Азийн хөгжлийн банк ““Тэжээлийн тогтвортой менежмент төсөл”-ийн байгууллагад хүсэлт хүргүүлсний үр дүнд 129,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Луус суманд 49.5 сая төгрөгний өртөгтэй газар тариалангийн зориулалттай 50 морины хүчтэй трактор, Хүнс, хөдөө аж ахуйн газарт 80 сая төгрөгийн өртөгтэй 50 морины хүчтэй трактор 4 дагалдах хэрэгслийн хамт олгож газар тариалан эрхлэгчдийг дэмжиж хамтарч ажилласан.Хаврын тариалалтад 10 өрхийн 6 га талбайг хагалж, хөрс боловсруулахад нь дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.<br>www.dundgovi.gov.mn Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нэртэй фейсбүүк хуудас, Дундговь аймгийн www.dundgovi.gov.mn сайтын Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаа мэдээлэл оруулах хэсэгт тайлан мэдээллийг оруулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 3.14 | Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил түүний тайлан; | Азийн 14 улсын Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний онлайн Флат Форум үүсгэх зорилгоор орон нутгийн брэнд болох хонь, ямааны мах, ямааны сүү, гүүний айраг, хөмүүл, таанын нарийвчилсан 80 дээжийг олон улсын байгууллагын лабораторид судлуулахаар судалгааны дээжийг хүргүүлсэн одоогоор хариу ирээгүй байна. www.dundgovi.gov.mn Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нэртэй фейсбүүк хуудас, Дундговь аймгийн www.dundgovi.gov.mn сайтын Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаа мэдээлэл оруулах хэсэгт тайлан мэдээллийг оруулсан. | |
| | 3.15 | хууль тогтоомжид заасан бусад. | Байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичгийн үйл ажиллагаа erp, DOCX токен цахим систем дээр бүрэн цахимжуулсан. Үүнд: Ирсэн явсан бичиг, өргөдөл гомдол, хүний нөөцийн үйл ажиллагаа, албан хаагчдын ирцийн бүртгэлүүд erp сүлжээнд бүрэн цахимжаад байна. Мөн байгууллагын даргын тоон гарын үсгийг баталгаажуулан суулгаж цахим албан бичиг явуулж байна. Байгууллагын албан хаагчид цахимаар өргөдөл гомдолоо хүлээн авч бүртгэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. 12 сарын 08-ны байдлаар тус байгууллагад иргэн, аж ахуй нэгж, албан хаагчдаас нийт 11-н өргөдөл гомдол ирсэнийг цахимд шивэн бүртгэлжүүлж 100% шийдвэрлэж хариуг хүргүүлсэн байна. Мөн ирсэн бичиг-245, явсан бичиг-247 байгааг 100% цахимаар солилцож бүртгэлжүүлсэн байна. Газрын болон албадын дарга нар албан хаагч нарт цахимаар 26 үүрэг даалгавар өгч 100 хувь хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |
| Дундаж оноо | | | | 100 |
| 4. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн | 4.1 | Үйлчилгээний төрөл, шийвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл | Хамааралгүй | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 4.2 | Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам олгосон сунгасан түдгэлзүүлсэн сэргээсэн хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг салбар төлөөлөгчийн газар зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа | Хүнс, хөдөө аж ахуйн газар нь зөвшөөрөл олгодоггүй. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зйүйлийн 15 [1].1.3 дахь заалтын дагуу аймгийн төвийн хүнсний худалдаа эрхлэгч 13 аж ахуй нэгж, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 1 аж ахуй нэгж, суманд худалдаа үйлчилгээ эрхлэгч 2 аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу ХХААХҮЯ-ны 08-00-02/28 дугаартай удирдамжийн хүрээнд төвөлвөгөөт бус хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн дүгнэлт гаргаж ажилласан. | 100 |
| Нийт оноо | | | | 100 |

ХЯНАСАН: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХЖАРГАЛ

ТАЙЛАН ГАРГАСАН: БИЧИГ ХЭРГИЙН
АЖИЛТАН Б.ДЭЛГЭРМАНДАХ